



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/56

Биндэр сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт, лабораторийн шинжилгээг
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4,9.5, 9.6, 9.8, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны А/72 дүгээр захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2026 оны А/28 дугаар тушаал тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Гэлэгжамц	Мал эмнэлгийн тасгийн дарга
Гишүүд:	Н.Болормаа	1-р багийн Засаг дарга
	Э.Мөнгөншагай	2-р багийн Засаг дарга
	Ж.Ганзоригт	3-р багийн Засаг дарга
	Х.Амарзаяа	4-багийн Засаг дарга
	Б.Тунгалаг	5-р багийн Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Цогтбаатар	Тархвар зүйч

2.Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 2026 оны 10 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд, лабораторийн тандах шинжилгээний ажлыг өвчний гаралт, тархвар зүйн судалгааг үндэслэн зохион байгуулсугай.

3.Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн Малын эмч (Н.Ган-Од, Ц.Ган-Од, Д.Алтанцэцэг, С.Шүрэнчулуун, Ш.Отгон) нарт, Урьдчилан сэргийлэх тарилга, лабораторийн шинжилгээ, халдваргүйтгэлийн ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж дүнг нэгтгэж танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Ц.Цогтбаатар)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд)-д, гүйцэтгэлийг вакцинжуулалт дууссанаас хойш 7 хоногийн дотор танилцуулж, тарилгын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Ц.Цогтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДЭМБЭРЭЛСАЙХАН

